

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/045/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ж.Баясгалан Утас: 7036-3047 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМАГ САЙХАН СУМЫН ЭРҮҮЛГ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ОДГЭРЭЛ ТАНАА**

2026.02.25 № СА-2026/ОХС/НА-СА-ТУС
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас 32,350.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн болон Боловсролын сайдын А/415, А/151 дүгээр тушаалаар хуваарилсан 3,499.1 мянган төгрөгийн үнэ бүхий зүрхний цахилгаан бичлэгийн аппарат зэрэг нийт 35,849.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгийн бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сайхан сумын ЭМТ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байгаа бөгөөд уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сайхан сумын ЭМТ нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 1 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.6 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		790,033,047.27	880,927,722.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	12,801,533.60	385,283,295.53
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		12,801,533.60	385,283,295.53
31210	Төгрөг		12,801,533.60	385,283,295.53
31211	Төрийн сангийн харилцах		12,801,533.60	385,283,295.53
33	АВЛАГА	5	662,872,850.48	397,784,857.95
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		639,639,673.48	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага		-	363,327,327.00
33500	Бусад авлага		23,233,177.00	34,457,530.95
33510	Байгууллагаас авах авлага		23,233,177.00	34,457,530.95
35	БАРАА МАТЕРИАЛ	6	114,358,663.19	97,859,569.32
35100	Түүхий эд материал		78,374,618.39	67,946,421.79
35130	Эм боох материал		78,374,618.39	67,946,421.79
35300	Бэлэн бүтээгдэхүүн		24,618,294.80	23,213,754.87
35400	Хангамжийн материал		11,365,750.00	6,699,392.66
35410	Бичиг хэргийн материал		1,185,400.00	360,500.00
35420	Аж ахуйн материал		8,746,030.00	5,193,100.00
35440	Түлш, шатах тослох материал		485,000.00	505,000.00
35460	Хүнсний материал		949,320.00	640,792.66
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		722,568,573.89	664,986,512.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	722,568,573.89	664,986,512.25
39200	Биет хөрөнгө		678,358,173.89	621,056,912.25
39201	Барилга, байгууламж, орон сууц		772,988,093.00	772,988,093.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(549,660,183.60)	(597,400,706.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		135,612,131.00	135,612,131.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(135,612,131.00)	(135,612,131.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		799,512,893.71	838,743,549.71
39206	Хуримтлагдсан элэгдэл		(395,420,990.07)	(440,912,489.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		92,930,564.00	84,602,732.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(53,145,849.75)	(46,730,285.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө		20,017,300.00	20,017,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(8,863,653.40)	(10,251,280.87)
39300	Биет бус хөрөнгө		44,210,400.00	43,929,600.00
39301	Програм хангамж		2,122,000.00	2,122,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(716,000.00)	(996,800.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		42,804,400.00	42,804,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,512,601,621.16	1,545,914,235.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		39,598,255.96	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		39,598,255.96	-
41300	Өглөг	9	39,598,255.96	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		17,193,590.96	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		22,404,665.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,473,003,365.20	1,545,914,235.05
51	Засгийн газрын хувь оролцоо		1,473,003,365.20	1,545,914,235.05

51100	Засгийн газрын оруулсан капитал		757,270,416.00	757,270,416.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		757,270,416.00	757,270,416.00
51200	Хуримтлагдсан үр дүн		(956,602,125.13)	(883,691,255.28)
51210	Өмнөх үеийн үр дүн		(1,146,766,368.51)	(956,602,125.13)
51220	Тайлант үеийн үр дүн		190,164,243.38	72,910,869.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,672,335,074.33	1,672,335,074.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,512,601,621.16	1,545,914,235.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	3,179,474,408.74	3,248,521,637.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,179,474,408.74	3,248,521,637.10
120	Нийтлэг татварын бус орлого		3,179,474,408.74	3,248,521,637.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		497,556,373.40	530,651,928.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		396,201,871.40	494,045,861.47
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		68,814,880.00	35,849,100.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		32,539,622.00	756,966.50
122	Тусламжийн орлого		-	2,416,459,409.10
1221	Хандив тусламж /дотоод/		-	2,416,459,409.10
12215	Төсөв хоорондын хандив, тусламж		-	2,416,459,409.10
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого /ЭМДС-УТ/		-	2,416,459,409.10
1221	Хандив тусламж /дотоод/			301,410,300.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого			301,410,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого			301,410,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,370,032,935.34	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		2,370,032,935.34	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		2,370,032,935.34	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		311,885,100.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		311,885,100.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		311,885,100.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	2,989,310,165.36	3,175,610,767.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,989,310,165.36	3,175,610,767.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,989,310,165.36	3,071,918,899.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,541,138,762.40	1,736,162,865.77
210101	Үндсэн цалин		829,104,234.97	1,094,260,860.27
210102	Нэмэгдэл		557,523,692.14	523,693,072.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт		29,959,701.19	50,720,000.00
210104	Урамшуулал		124,551,134.10	67,488,932.70

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		188,801,484.14	238,324,222.94
210201	Тэтгэврийн даатгалын зардал		140,137,117.82	165,893,642.91
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		14,305,478.30	19,460,337.81
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		7,152,600.00	10,715,016.76
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		7,152,600.00	7,718,848.47
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		20,053,688.02	34,536,376.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		291,885,100.00	253,672,679.63
210301	Гэрэл, цахилгаан		18,273,060.66	20,063,486.52
210302	Түлш, халаалт		258,432,711.34	221,257,865.11
210303	Цэвэр, бохир ус		15,179,328.00	12,351,328.00
2104	Хангамж, бараа материалын зардал		55,783,279.94	59,713,343.00
210401	Бичиг хэрэг		15,385,460.00	9,804,170.00
210402	Тээвэр, шатахуун		17,540,000.00	12,905,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,571,559.94	3,992,485.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,065,000.00	5,403,168.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		18,221,260.00	27,608,520.00
2105	Нормативт зардал		695,257,256.87	615,937,946.87
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		647,821,689.87	578,331,683.53
210502	Хоол, хүнс		38,930,567.00	33,779,263.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		8,505,000.00	3,827,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		43,446,220.00	29,269,630.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,465,900.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		196,000.00	-
210604	Урсгал засвар		41,784,320.00	29,269,630.00
2107	Томилолт, зочны зардал		6,529,100.00	10,364,400.00
210702	Дотоод албан томилолт		6,529,100.00	10,364,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,107,975.00	5,336,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		516,000.00	4,855,500.00
210803	Даатгалын үйлчилгээ		170,775.00	204,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		421,200.00	209,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		-	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		165,360,987.01	123,137,681.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		5,975,380.00	6,193,720.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		159,385,607.01	116,943,961.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		-	76,854,217.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		-	76,854,217.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		-	35,194,217.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		-	40,860,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		-	800,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		190,164,243.38	72,910,869.88
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		190,164,243.38	72,910,869.88
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-

213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан уруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал			-	-
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал				26,837,650.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,523,146,333.26	3,477,003,563.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,523,146,333.26	3,477,003,563.10
120	Нийтлэг татварын бус орлого	379,181,778.40	482,021,507.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	379,181,778.40	482,021,507.52
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	379,181,778.40	482,021,507.52
122	Тусламжийн орлого	-	2,994,982,055.58
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,994,982,055.58
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	302,210,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого /ЭМГ-аас/	-	800,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого /Орон нутгийн төсвөөс/	-	301,410,300.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	2,692,771,755.58
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого /ЭМДС-УТ/	-	2,692,771,755.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,832,079,454.86	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,832,079,454.86	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,832,079,454.86	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	311,885,100.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	311,885,100.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,763,429,219.02	3,104,521,801.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,763,429,219.02	3,104,521,801.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,763,429,219.02	2,977,317,133.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,536,702,825.70	1,761,368,802.57
210101	Үндсэн цалин	824,668,298.27	959,994,720.33
210102	Нэмэгдэл	557,523,692.14	581,210,433.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,959,701.19	80,890,147.90
210104	Урамшуулал	124,551,134.10	139,273,500.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,607,893.18	230,060,877.10
210201	Тэтгэврийн даатгалын зардал	122,943,526.86	128,318,277.10
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	14,305,478.30	25,435,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	7,152,600.00	12,717,800.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	7,152,600.00	12,717,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	20,053,688.02	50,871,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,885,100.00	253,672,679.63
210301	Гэрэл, цахилгаан	18,273,060.66	20,063,486.52
210302	Түлш, халаалт	258,432,711.34	221,257,865.11
210303	Цэвэр, бохир ус	15,179,328.00	12,351,328.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,157,259.94	40,959,703.00
210401	Бичиг хэрэг	12,220,200.00	8,762,350.00

210402	Тээвэр, шатахуун	16,500,000.00	13,224,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,941,559.94	3,992,485.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,283,900.00	5,403,168.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,211,600.00	9,577,700.00
2105	Нормативт зардал	664,456,085.20	633,304,081.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	613,542,755.20	588,146,645.50
210502	Хоол, хүнс	38,603,630.00	33,470,736.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,309,700.00	11,686,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,557,600.00	35,830,740.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,565,900.00	-
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	196,000.00	-
210604	Урсгал засвар	30,795,700.00	35,830,740.00
2107	Томилолт, зочны зардал	6,529,100.00	10,140,400.00
210702	Дотоод албан томилолт	6,529,100.00	10,140,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,557,975.00	5,647,630.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	966,000.00	5,167,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	204,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	421,200.00	209,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,975,380.00	6,332,220.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,975,380.00	6,332,220.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	103,691,867.37
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		26,837,650.37
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		26,837,650.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	76,854,217.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35,194,217.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	40,860,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	800,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(240,282,885.76)	372,481,761.93
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	21,088,400.00	23,512,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,088,400.00	23,512,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,088,400.00	23,512,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,088,400.00	23,512,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(21,088,400.00)	(23,512,800.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(261,371,285.76)	372,481,761.93
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	274,172,819.36	12,801,533.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,801,533.60	385,283,295.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэг-дэл	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Нийт дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	757,270,416.00	1,672,335,074.33	-1,146,766,368.51	0.00	1,282,839,121.82
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-1,146,766,368.51	0.00	1,282,839,121.82
Тайлант үеийн үр дүн	-	-	190,164,243.38	0.00	190,164,243.38
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-956,602,125.13	0.00	1,473,003,365.20
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-956,602,125.13	0.00	1,473,003,365.20
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-956,602,125.13	0.00	1,473,003,365.20
Тайлант үеийн үр дүн	-	-	72,910,869.85	0.00	72,910,869.85
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-883,691,255.28	0.00	1,545,914,235.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,154,134,000.00	3,373,311,695.73	780,822,304.27	81.20
12	Татварын бус орлого	4,154,134,000.00	3,373,311,695.73	780,822,304.27	81.20
120	Нийтлэг татварын бус орлого	378,034,000.00	405,967,290.52	(27,933,290.52)	107.39
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	378,034,000.00	405,967,290.52	(27,933,290.52)	107.39
122	Тусламжийн орлого	3,776,100,000.00	2,967,344,405.21	808,755,594.79	78.58
122001	Хандив тусламж /дотоод/	3,441,977,500.00	2,692,771,755.58	749,205,744.42	78.23
122005	Төсвөөс санхүүжих /Орон нутгийн төсвөөс/	334,122,500.00	274,572,649.63	59,549,850.37	82.18
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,168,741,300.00	3,000,829,933.80	1,167,911,366.20	71.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,168,741,300.00	3,000,829,933.80	1,167,911,366.20	71.98

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,168,741,300.00	3,000,829,933.80	1,167,911,366.20	71.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,543,569,000.00	1,761,368,802.57	782,200,197.43	69.25
210101	Үндсэн цалин	1,203,381,200.00	959,994,720.33	243,386,479.67	79.77
210102	Нэмэгдэл	827,227,000.00	581,210,433.39	246,016,566.61	70.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	177,735,800.00	80,890,147.90	96,845,652.10	45.51
210104	Урамшуулал	335,225,000.00	139,273,500.95	195,951,499.05	41.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	317,946,000.00	230,060,877.10	87,885,122.90	72.36
210201	Тэтгэврийн даатгал	216,203,400.00	128,318,277.10	87,885,122.90	59.35
210202	Тэтгэмжийн даатгал	25,435,700.00	25,435,700.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,717,800.00	12,717,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,717,800.00	12,717,800.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	50,871,300.00	50,871,300.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	313,122,500.00	253,672,679.63	59,449,820.37	81.01
210301	Гэрэл, цахилгаан	30,060,800.00	20,063,486.52	9,997,313.48	66.74
210302	Түлш, халаалт	259,331,200.00	221,257,865.11	38,073,334.89	85.32
210303	Цэвэр, бохир ус	23,730,500.00	12,351,328.00	11,379,172.00	52.05
2104	Хангамж, бараа материалын зардал	111,361,700.00	40,959,703.00	70,401,997.00	36.78
210401	Бичиг хэрэг	33,345,100.00	8,762,350.00	24,582,750.00	26.28
210402	Тээвэр, шатахуун	28,632,300.00	13,224,000.00	15,408,300.00	46.19
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,700,000.00	3,992,485.00	3,707,515.00	51.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,727,700.00	5,403,168.00	5,324,532.00	50.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,956,600.00	9,577,700.00	21,378,900.00	30.94
2105	Нормативт зардал	741,708,300.00	633,304,081.50	108,404,218.50	85.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	666,491,300.00	588,146,645.50	78,344,654.50	88.25
210502	Хоол, хүнс	51,005,000.00	33,470,736.00	17,534,264.00	65.62
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,212,000.00	11,686,700.00	12,525,300.00	48.27
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,081,600.00	59,343,540.00	47,738,060.00	55.42
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,875,000.00	20,727,800.00	23,147,200.00	47.24
210602	Тавилга	-	2,785,000.00	(2,785,000.00)	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,955,000.00	-	1,955,000.00	-
210604	Урсгал засвар	61,251,600.00	35,830,740.00	25,420,860.00	58.50
2107	Томилолт, зочны зардал	11,810,000.00	10,140,400.00	1,669,600.00	85.86
210702	Дотоод албан томилолт	11,810,000.00	10,140,400.00	1,669,600.00	85.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,642,200.00	5,647,630.00	5,994,570.00	48.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,857,200.00	5,167,000.00	2,690,200.00	65.76
210803	Даатгалын үйлчилгээ	2,675,000.00	204,930.00	2,470,070.00	7.66

210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	209,700.00	790,300.00	20.97
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	66,000.00	44,000.00	60.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,500,000.00	6,332,220.00	4,167,780.00	60.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,500,000.00	6,332,220.00	4,167,780.00	60.31
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(14,607,311.60)	372,481,761.93	(387,089,073.53)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,607,311.60	12,801,533.60	1,805,778.00	87.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	385,283,295.53		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58.00	56.00	-	96.50
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	57.00	55.00	-	96.50

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын ЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн, шалгуур хангаагүй үндэслэлээр ЭМДС-аас санхүүжилт хасуулсан, байдлын тайлангийн эмийн үлдэгдэл эмийн программын үлдэгдэлтэй зөрүүтэй тайлагнагдсан зэрэг зөрчилтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,989,310.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 29,893.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сайхан сумын ЭМТ нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хуулийн хүрээнд төсвийн гүйцэтгэлийг зориулалтын дагуу зарцуулж, шаардлагагүй худалдан авалт хийлгүй төсвийн хөрөнгийг хэмнэж ажилласан,
- Сул орон тоонд шинээр ажилтан томилоогүй бөгөөд цалингийн зардлыг хэмнэсэн,
- Байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр усны хэрэглээг хэмнэх талаар ажилчдын шуурхай хурлаар чиглэл өгч, цахилгаан, цэвэр усны зардлыг хэмнэсэн,
- Сонин, хэвлэл, сэтгүүлийн захиалга хийгээгүй гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сумын ЭМТ нь мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт,*
- *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал,*
- *Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт,*
- *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан,*

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 431 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан томилолтын зардалтай давхардуулан хоолны хөнгөлөлт олгосон зөрчилд 540,0 мянган төгрөгийн төлбөрийн акт, шууд худалдан авах босго үнээс давсан эм, эмнэлгийн хэрэгсэл шууд худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага, эмийн зарлагын баримтыг маягтын дагуу бүрэн гүйцэт хөтлөөгүй зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	540.0	1	540.0	100
Албан шаардлага	1	166,617.1	1	166,617.1	100
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	3	167,157.1	3	167,157.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудит болон дараагийн аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Тайлант онд ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 2.4.2-т “Төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуустал хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх” гэж заасныг мөрдлөг болгон ЭМДС-аас авах 12 дугаар сарын 11-ээс 31-ийг хүртэлх хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний авлага болох 2,933.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Тус төвийн тайлант онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 албан хаагчид 40,860.0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон боловч ХХОАТ суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:” 6.3.1 дэх “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1 дэх “Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар тайланд онд худалдан авсан 23,512.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлаар тайлагнаагүй алдаа илэрч аудитын явцад залрууллаа.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.4¹ дэх, УСНББОУС-2 “Мөнгөн гүйлгээний тайлан”-ийн 25 дугаар параграф²-д, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 5.4(б) дэх заалтууд болон “Ангилал” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 52,967.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, 622.5 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 450.0 мянган төгрөгийн зөрчлийн давтан гаргахгүй ажиллах 1 зөрчилд албан шаардлага, буруутай албан хаагчид хариуцлага тооцох 1 албан шаардлага, 51,895.3 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,072.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 28,820.6 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

¹ Төсвийн захирагчийн тайланд дараах мөнгөн орлого, зарлагыг тохируулна: Тухайн жилийн батлагдсан урсгал зардлын төсвөөр санхүүжүүлсэн хөрөнгийн шинжтэй гүйлгээг тохируулах бөгөөд тухайн гүйлгээ гарсан урсгал зардлын ангиллаас **биет ба биет бус хөрөнгө худалдан авсан хөрөнгийн зардалд**;

² Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа: Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна: а) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон урт хугацаат хөрөнгийг худалдан авахад төлсөн мөнгө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Шинээр ажилд албан хаагчид улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажиллаагүй сарыг оруулан тооцож 308.2 мянган төгрөг илүү олгосон,
- Сахилгын шийтгэлтэй ажилтны сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 314.3 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал тооцож олгосон.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.7-д *“Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн **сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй**”*, 2.5-д *“Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан **ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно**”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 450.0 мянган төгрөг мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд бүлэг хооронд зориулалт бусаар гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Аймгийн ЭМГ-ын шалгалтаар хоол үйлдвэрлэлийн дотоод хяналтын журамгүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй зөрчил илэрч 1,000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан байна. Зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцолгүй торгуулийг бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас төлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЭМДС-аас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь эх олонлогийн, системийн, эмч, байцаагчийн гэсэн 4 төрлөөр 51,895.3 мянган төгрөгөөр хасагдсан байгаа нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын шалгуур болон “Нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэхэмжлэхийн хяналтаар хасагдсан тусламж, үйлчилгээний санхүүжилтэд сар бүр дүн шинжилгээ хийж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх замаар тусламж, үйлчилгээний орлогын бүрэн төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан үндсэн хөрөнгийг биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлаар тайлагнаагүй	1	23,512.8					1	23,512.8				
Дүн	1	23,512.8					1	23,512.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон	2	622.5	2	622.5								
Зориулалт бусаар зарцуулсан	1	450.0			1	450.0						

Хариуцлага тооцох албан шаардлага	1	-						1	1			
Дүн	4	1,072.5	2	622.5	1	450.0	-	-	1	1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тусламж үйлчилгээний санхүүжилт хасагдсан	1	51,895.3					1	51,895.3
Дүн	1	51,895.3					1	51,895.3
Нийт дүн	2	51,895.3					2	51,895.3